


ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХХК
ТӨВИЙН ҮЙЛДВЭР
ГАДНА ГЭРЭЛТҮҮЛГИЙН
ТӨЛӨВЛӨЛТ



ТАЙЛБАР :

Төвийн үйлдвэр нь нийт 16855м²/ 1,8 га талбайтай.
 Үүнээс 1700 м²/ талбай нь түлш хураах болон ачилтын талбай .
 8345 м² / талбай нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талбай.
 6810 м² / талбай нь зам талбай гарц орц эзэлж байна.
 Одоо байгаа түлш хураах талбайд 2023 оны төсөвт тавигдсан 20х15 метр ажилчдын ахуйн байр, цайны газар болон оффисын барилга барих төлөвтэй .
 Төлөвлөж буй 9ширхэг Цамхагт гэрэлтүүлэг
 Төлөвлөж буй 30ширхэг замын гэрэлтүүлгийн шон
 Төлөвлөж буй 1ширхэг Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэг

- Одоо байгаа түлш хураах талбай
- Барилга / Гал тогоо /
- Харуулийн байр
- ХАБ байр
- Сэлбэг хэрэгслийн контейнер
- Хогийн цэг



"ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ"ХХК

ТӨВИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАДНА ГЭРЭЛТҮҮЛГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

ТӨВИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАДНА ГЭРЭЛТҮҮЛГИЙН ТӨЛӨВЛӨЛТ				ТБХ:	
				Материал:	Ve шат:
Баталсан	Ж.Даваацэрэн		ЕГ Шифр:	Масштаб:	Огноо:
Шалгасан	Э.Батхишиг		ТБХ.ТВ.2023.09.19		
Хянасан	Б.Тайвандат		ТГ Шифр:	Зургийн дугаар:	Хуудас:
Гүйцэтгэсэн					

**“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХХК -ИЙН ТӨВИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАДНА ТАЛБАЙН
ЦАМХАГТ ГЭРЭЛТҮҮЛЭГ, ГЭРЭЛТҮҮЛГИЙН ШОН ӨӨРӨӨ ӨРГӨГЧ ЦАМХАГТ
ГЭРЭЛТҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

20... оны ... сарын ... өдөр

№

Улаанбаатар хот

<p>1. Зураг төсөл боловсруулах үндэслэл</p>	<p>“Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дүгээр сарын 18-ний өдрийн 62 дугаар тогтоол “Нийслэл Улаанбаатар хотын баруун бүсэд сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барьж ашиглалтанд оруулах” үндэслэн Тавантолгой түлш” ХХК -ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө</p>
<p>2. Барилга байгууламжийн байршил</p>	<p>Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо “Таван Толгой Түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний Төвийн үйлдвэрийн зам талбай</p>
<p>3. Зориулалт, хүч чадал (бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлөөр)</p>	<ul style="list-style-type: none"> – Үйлдвэрийн гадна талбайн гэрэлтүүлэг: – 14метрийн өндөртэй 9-н ширхэг цамхагт гэрэлтүүлэг – 6метрийн өндөртэй 30ширхэг замын гэрэлтүүлгийн шон – 20м өндөртэй 1ширхэг Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэг
<p>4.Үйлдвэр аж ахуйн газар, барилга байгууламжийн бүрэлдэхүүн шаардлага</p>	<p>Ерөнхий шаардлага</p> <ul style="list-style-type: none"> – Төвийн үйлдвэрийн гадна зам талбайн гэрэл гэрэлтүүлэг сайжруулах ажиллах орчин нөхцөл сайжруулах – Цамхагт гэрэлтүүлгийн цамхаг болон удирдлагын самбар шитэнд стандартын шаардлага хангасан газардуулгатай байх – Одоо байгаа гадна талбайн гэрэлтүүлгийн цахилгааны шитнээс тусдаа шиттэй байх – Цамхагт гэрэлтүүлэг хоорондын зай болон байршилыг захиалагчтай зөвшилцөх

	<ul style="list-style-type: none"> – LED цагаан өнгийн гэрэлтүүлэгтэй байх / бүрхэг буюу бороо цастай өдөр саадгүй ажиллана/ – Байгалийн ба зохиомол гэрэлтүүлгийн БНБД 23-02-08 стандартын дагуу
<p>5. Барилга байгууламжийн бүтээц материал, ерөнхий шаардлага</p>	<p>ЦАХИЛГААН МОНТАЖ ХОЛБОЛТ</p> <ul style="list-style-type: none"> – Цамхагт гэрэлтүүлэг, замын гэрэлтүүлгийн шонгын гэрэлтүүлэгч нь ус чийгний хамгаалалттай өвөл зуны аль ч нөхцөлд ажиллах чадвартай байх – Гэрэлтүүлэгч нь хойд, урд жигүүр гэсэн хоёр тусдаа гаргалгаанаас авах – Гэрэлтүүлэгчийн ерөнхий тэжээлийг 0,4кВ-н хувиарлах байгууламжын гадна гэрэлтүүлэг №1,№2 150А тай гаргалгаанаас авах – Цамхагт гэрэлтүүлгийн гэрэлтүүлэгч нь IP67 800Вт чадалтай цагаан өнгийн тусгалтай лед байх – Цамхагт гэрэлтүүлэгч нь 4 зүгт /баруун, урд, хойд, зүүн/ тусгалтай бол 8 ширхэг 3 зүгт/ баруун, зүүн, хойд/ тусгалтай бол 6 ширхэг 800Вт чадалтай лед прожуктор суурьлуулна – Замын гэрэлтүүлгийн шонгын гэрэлтүүлэгч нь IP67 250Вт чадалтай цагаан өнгийн тусгалтай лед байх – Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч нь 20 метрийн өндөртэй 1ширхэг байх – Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч дээр 10ширхэг 800Вт-н чадалтай цагаан өнгийн тусгалтай IP67 битүүмжлэлтэй гэрэлтүүлэгч байх

- Гэрэлтүүлгийн тэжээлийн кабелийг газар доорхи 0.7м гүнд кабелийн стандартын шаардлага хангасан хамгаалалтын хоолой болон элс тоосгоор хамгаалсан байх
- Гэрэлтүүлгийн тэжээлийн кабель нь 10мм дээш голчтой 4 жилтэй /АВВГЗ*35 1*25/ маркийн кабель байх
- Цамхагт гэрэлтүүлэг нь тус бүрдээ IP 67-оос дээш битүүмжлэлтэй удирдлагын самбартай, удирдлагын хэсэг болон электрон цагийн механизмтай байх
- Замын гэрэлтүүлгийн шонгийн тэжээл нь IP 67-оос дээш битүүмжлэлтэй удирдлагын самбартай, удирдлагын хэсэг болон электрон цагийн механизмтай байх
- Цамхагт гэрэлтүүлгийн удирдлагын самбар дээр анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, удирдлагын схем зургийн самбарын дотор талд зурж байрлуулах
- Цамхагт гэрэлтүүлгийн удирдлагын самбар дээр гэрэл цацруулагч байрлуулах
- Гэрэлтүүлгийн шон нь босоо хэсэгт лед туузан гэрлээр хоёр талд нь дагуулж асаах

ЦАМХАГТ ГЭРЭЛТҮҮЛГИЙН ШОН

- Цамхагт гэрэлтүүлгийн шон 14м өндөртэй оройн хэсэгт ажлын давцантай, ажлын давцан нь хээтэй листээр хийх
- Давцангын хөвөө нь 15см өндөртэй листээр хийсэн байх
- Давцан дээрх хамгаалалтын хаалт хашилтын хоорондын зай 40см багагүй

байх ба гэрэлтүүлэг байрлуулах давцанг хийсэн байх

- Цамхагт гэрлтүүлгийн ажлын давцанд гарах шатыг стандартын дагуу хийх ба газрын түвшинөөс дээш 1,5м эхлэн ажлын давцанлуу гарах хүртэл хамгаалалт хийх
- Ажлын давцан руу гарах хүртэлх шатны хамгаалалтын бүслүүрийн зай 40см-с багагүй байх
- Цамхагт гэрэлтүүлгийн шонг цагаан цайвар өнгөөр будах газрын түвшинээс 2м хүртэлх зайнд цацруулагч байрлуулах
- Цамхагт гэрэлтүүлгийн суурь нь газрын түвшинөөс доош байрлах ба хөл тус бүрд суурийн бетон байрлуулж анкарын боолтоор боох
- Цамхагт гэрэлтүүлгийн суурь нь тэжээлийн кабель орох гарах сүвэлгээний хоолойтой байх
- Анкарын боолтыг зэвэрдэггүй нано түрхлэг болон цацлага хийх

ЗАМЫН ГЭРЭЛТҮҮЛГИЙН ШОН

- Замын гэрэлтүүлгийн шон 6м өндөртэй гэрлийн тусгалыг 45градуст тусгахаар хийх
- Замын гэрэлтүүлгийн шонг зөөвөрлөж болохоор анкар нь боолттой бетонон суурьтай байх
- Суурийг нь цахилгааны тэжээлийн кабель орох гарах сүвэлгээний хоолойтой байх

- Замын гэрэлтүүлгийн шонг ганддаггүй хуулардаггүй цагаан будгаар будах
- Замын гэрэлтүүлгийн шон нь цахилгаан холболтын үүртэй, холболтыг нь зориулалтын клем холбосон байх.
- Замын гэрэлтүүлгийн шонгын холболтын үүрнээс гэрэлтүүлэг хүртэлх кабель нь КГ2*2,5 байх
- Замын гэрэлтүүлгийн шон болгоны босоо хэсэгт газрын түвшинээс 1,5м хүртэлх зайд цацруулагч тууз наасан байх
- Суурин анкар боолт болгонд зэврэлтээс хамгаалдаг нано цацлага, түрхлэг хийх

ӨӨРӨӨ ӨРГӨГЧ ЦАМХАГТ ГЭРЭЛТҮҮЛЭГ

- Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч нь 20м өндөртэй 1ширхэгийг ачилтын талбайн гол хэсэгт байрлуулна
- Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгчийн суурь нь газрын түвшинээс доош байрлах ба хөл нь суурийн бетон байрлуулж анкарын боолтоор боох
- Анкарын боолтыг зэвэрдэггүй нано түрхлэг болон цацлага хийх
- Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч нь 800Вт-н IP67 LED 10 ширхэг гэрэлтүүлэгтэй байна
- Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч нь гэрэлтүүлэгийн суурь хэсгийг өөрөө автомтаар буулгагчтай байх

	<ul style="list-style-type: none"> – Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч нь өөр дээрээ аянга зайлуулагч газардуулагчтай байх – Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч нь зэвэрдэггүй гангаар хийгдсэн байх – Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч нь 50метр радиус талбайг гэрэлтүүлэх налуу тусгалтай байх – Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгчийг тойрсон хамгаалалтын хаалт хашилттай байх – Хамгаалалтын хаалт хашилт нь гэрэлтдэг будагаар будсан байх ахнааруулах пайзтай байх – Өөрөө өргөгч цамхагын босоо шон гурван талдаа газрын түвшинээс 20 см дээш гэрэлтүүлэгч хүртэл туузан гэрэлтэй байх – Өөрөө өргөгч цамхагт гэрэлтүүлэгч нь IP 67-оос дээш битүүмжлэлтэй удирдлагын самбартай, удирдлагын хэсэг болон электрон цагийн механизмтай байх
<p>6. Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр /дулаан, ус хангамж ариутгах татуурга, цахилгаан холбоо, инженерийн хангамж/</p>	<ul style="list-style-type: none"> – Цахилгаан хангамж: Таван толгой түлш төвийн үйлдвэр өөрийн эзэмшлийг дэд станц 0,4кВт-н хувиарлах байгууламж – Холбоо дохиолол: Шугам сүлжээний тодруулга авна.
<p>7. Зураг төсөл зохиох үе шат</p>	<ul style="list-style-type: none"> – 1 үе шаттай – Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэс болгоно.

8. Ажиллах горим	<ul style="list-style-type: none">– Гадна орчины температур +25 -40 градуст хэвийн ажилдаг байх– Борооны ус болон тоос тоосонцорын хамагаалалт IP67 дээш байх
9. Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага	“Тавантолгой түлш” ХХК
10. Барилга угсралтыг гүйцэтгэх хугацаа	– 2023 оны 10-р сар
11. Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ	<i>Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.</i>